

**ХОВД АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Нэг. Төрийн удирдлага, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.1. Төрийн байгуулалтын талаар:

1.1.1. Төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгох ажлыг үргэлжлүүлнэ.

1.1.2. Төрийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага, шалгуурыг өндөржүүлнэ.

1.1.3. Боловсон хүчнийг сургаж дадлагажуулах замаар төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлнэ.

1.1.4. Аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлын мэдээллийг иргэдэд ил тод мэдээлж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, иргэдийн санал бодлыг сонсох “Иргэдийн өдөр”-ийг нэгдсэн хуваарийн дагуу зохион байгуулна.

1.1.5. Аймгийн иргэний танхимуудын үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг иргэдээрээ тухай бүр нь хэлэлцүүлж шийдвэрлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

1.1.6. “Цахим засаглал” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, төрийн байгууллагаас гаргасан шийдвэрүүд, төсөв санхүүг цахим мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хүргэх, иргэд санал хүсэлт, өргөдөл, гомдлоо чөлөөтэй илэрхийлэх, хариугаа бичгээр болон цахим хэлбэрээр түргэн шуурхай авах асуудлыг шийдвэрлэнэ.

1.1.7. Нутгийн удирдлага, захиргааны байгууллагаас дэвшүүлсэн хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодит санал санаачилга, төсөл хөтөлбөрийг дэмжиж хамтран ажиллана.

1.1.8. Сумдаас ирүүлсэн санал, судалгааг үндэслэн сумдын ЗДТГ-ын автомашин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, багийн Засаг дарга нарыг унаажуулах, багийн төвүүдийн барилгыг шинээр барих асуудлыг шийдвэрлэнэ.

1.1.9. Уламжлалт харилцаатай орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлж оюутан сургах, солилцох, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

1.1.10. Сум, байгууллагуудын үйл ажиллагаанд хоёроос доошгүй удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

1.1.11. Хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт, төрийн үйлчилгээ иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын болон төрийн албан

хаагчдын үйл ажиллагааны талаар иргэдээс авах санал асуулгыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

1.1.12. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлах ном, гарын авлага хэвлүүлж тараана.

1.1.13. Ховд хотын 330 жилийн ойг тэмдэглэнэ.

1.1.14. Ард иргэдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах аргад сургаж дадлагажуулах зорилгоор нэг суманд гамшгаас хамгаалах дадлага сургууль зохион байгуулна.

1.1.15. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг бүх нийтэд шуурхай хүргэж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дохиогоор ажиллах арга ажиллагаанд сургаж дадлагажуулна.

1.1.16. Дуут, Мөнххайрхан сумын нутгийн удирдлагын ордны барилгын ажлыг гүйцээж, ашиглалтад оруулна.

1.2. Эрх зүйн бодлогын талаар:

1.2.1. “Архигүй, тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн эхний үе шатны ажлуудыг зохион байгуулна.

1.2.2. “Хууль дүрэм бодит амьдралд” аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн ажлын үр нөлөөг сайжруулна.

1.2.3. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

1.2.4. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.

1.2.5. Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээлгэсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллана.

1.2.6. Хоёр суманд Цагдаагийн кабон барина.

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд:

2.1. Боловсролын чиглэлээр:

2.1.1. ЕБС-д суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, суурь боловсролын хамран сургалтыг 95.6 хувьд хүргэнэ.

2.1.2. Хөдөөгийн багуудад гэр цэцэрлэгүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 80.5 хувьд хүргэж, цэцэрлэг байгуулах, хүүхэд харах, асрах үйлчилгээ нээж ажиллуулахыг дэмжинэ.

2.1.3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил, ёс зүй, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Багшийн хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.4. Хүүхдийн авъяас, билгийг багаас нь нээн хөгжүүлэх зорилгоор “Зөв Монгол хүүхэд”, “Авъяас”, “Ном” хөтөлбөрийг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

2.1.5. Үндэсний лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлж, сургалтын дэвшилтэт технологийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлнэ.

2.1.6. Насан туршийн боловсрол төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд амьдрах ухааны боловсрол олгох насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.1.7. Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, цахим сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.8. Дотуур байрны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, Мөст, Чандмань сумын дотуур байрыг ашиглалтад оруулна.

2.1.9. Үенч, Жаргалант сумын I сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.

2.1.10. Цаст-Алтай цогцолбор, Буянт, Мөнххайрхан сумын сургуулийн их засварыг холбогдох газруудад уламжлан шийдвэрлэнэ.

2.1.11. Булган, Зэрэг, Мөст, Үенч сумын цэцэрлэг, Бичигт багт 13 дугаар цэцэрлэгийг ашиглалтад оруулж, хувийн цэцэрлэгүүдийг төсвийн хөрөнгөөр дэмжинэ.

2.1.12. Нэг сургууль, цэцэрлэгийг эрчим хүчний үр ашгийн төсөлд хамруулна.

2.1.13. Орон нутагт чухал шаардлагатай, нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай эмч, багш, инженер, технологич нарт зориулсан орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.14. Ховд их сургууль, Хөгжил политехник коллежийг түшиглэсэн инноваци технологийн инкубатор төвийг дэмжиж, зарим судалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

2.1.15. “Хөгжил” политехник коллежийн техник технологийн шинэчлэл хийж, сургалтын хөтөлбөрийг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн шинэчилж, түншлэлийг өргөжүүлнэ.

2.1.16. ХоИС-д сургуулийн өмнөх боловсролын багш, соёл, инженер техникийн мэргэжилтэн бэлтгэх ангиудыг шинээр нээж, ерөнхий боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг өргөжүүлнэ.

2.1.17. Бүс нутгийн байгалийн баялаг, хүн ардын түүх, соёлд холбогдох суурь судалгааны ажлыг өргөжүүлж “Баруун Монголын түүх соёл, байгалийн нөхцөл, нөөц ашиглалт” олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.

2.1.18. Аймаг, бүсийн түвшинд хэрэгжүүлж буй хөгжлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой хэрэглээний болон бодлогын судалгааг хэрэгжүүлж, орон нутгийн чадавхийг бүрдүүлнэ.

2.1.19. “ХАА-н шинжлэх ухаан, үйлдвэр технологийн парк” байгуулах ажлыг Шинжлэх ухааны академи болон ҮХААЯ, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.1.20. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулж, мэдлэг, чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдралын ур чадвартай өсвөр үе, залуучуудыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.

2.1.21. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролд тэгш, хүрээмжтэй хамруулж, мэргэшсэн багш нарыг үе шаттай бэлтгэнэ.

2.1.22. Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж буй шинэчилсэн сургалтын цөм хөтөлбөрийг СӨБ, ЕБС-д хэрэгжүүлж, хүүхэд нэг бүрийн хөгжил төлөвшлийг хангаж ажиллана.

2.2. Эрүүл мэндийн чиглэлээр:

2.2.1. Иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулж, өвчнийг эрт оношлон эрүүлжүүлэх ажлыг графикаар зохион байгуулна.

2.2.2. “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлэн, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулж, мянганы хөгжлийн зорилтыг хангана.

2.2.3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрхийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлнэ.

2.2.4. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг Монгол, Бельгийн Засгийн газрын чадавхжуулах төсөлд хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, эмч мэргэжилтнүүдийг сургана.

2.2.5. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж төр, хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.

2.2.6. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж сумдын эрүүл мэндийн төвийн оношилгоо, эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.7. Зарим сумдын эмнэлэг, Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн усан хангамжийг сайжруулах, цэвэр бохир усны сүлжээнд холбох арга хэмжээг дэс дараатайгаар шийдвэрлэнэ.

2.2.8. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Ховд, Дуут сумын түргэн тусламжийн машиныг шинэчилнэ.

2.2.9. Зарим сум, өрхийн эрүүл мэндийн төвийн засвар хийж, Буянт өрхийн эрүүл мэндийн төвийг төвлөрсөн халаалтын системд холбож, Бугат, Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийг цахилгаан халаалтад шилжүүлнэ.

2.2.10. Зоонозын өвчин судлалын төвд шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалалтын хувцас хэрэглэл нийлүүлж, Жаргалант суманд эмнэлгийн ороох, боох материалын үйлдвэр байгуулна.

2.2.11. “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдэд эмийн зохистой хэрэглээний сургалт мэдээллийг тогтмолжуулж, БОЭТ, сумдын эмнэлгүүдийн стационарт хэрэглэгдэх эмийг тендэрээр хангана.

2.3. Соёл, спорт аялал жуулчлалын чиглэлээр:

2.3.1. Музей, Өв соёлын хүрээлэнгийн үзмэрийг баяжуулж, ардын зан үйлийг төлөвшүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.3.2. Улаанбаатар хотод Ховд аймгийн соёлын өдрүүдийг зохион байгуулна.

2.3.3. Номын сангуудын фондыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, мэдлэг агуулсан номоор баяжуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлнэ.

2.3.4. “Аваргууд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тамирчдын бэлтгэл хийх орчин, нөхцөлийг сайжруулж, улсын болон олон улс, бүсийн тэмцээнийг 2-оос доошгүй төрлөөр зохион байгуулан өндөр амжилт гаргасан тамирчдыг урамшуулна.

2.3.5. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйл хэрэг болгох хөдөлгөөн өрнүүлж ажиллана.

2.3.6. Олон үндэстэн, ястны соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан сурталчлах, нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Алтан өв” хөтөлбөрийг хэрэгжүүлж, туулийн наадам зохион байгуулна.

2.3.7. Жаргалант суманд соёл спортын цогцолбор, Манхан суманд спорт заал, Үенч суманд соёлын төвийн барилгын ажлыг гүйцээж, ашиглалтад оруулна.

2.3.8. Түүх соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг фото болон цахим бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2.3.9. “Мянган угалзат” ОНӨҮГ-ын хуучин уурын зуух орчмын талбайг спортын талбай болгон тохижуулна.

2.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

2.4.1. Хөтөлбөрийн хүрээнд 500 хүний ажлын байр бий болгож, мэргэжлийн түр сургалтад шаардлагатай хүмүүсийг хамруулж, ажлын байраар хангана.

2.4.2. Өрх толгойлсон эх, эцгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.4.3. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.4.4. Хүүхэд бүрд сар бүр 20000 төгрөг олгох төрийн бодлогыг орон нутагт зохион байгуулж, нийгмийн халамж, тусламж авах иргэдийг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.4.5. Бүтэн өнчин хүүхдэд аймгийн Засаг даргын тэтгэлгийг үргэлжлүүлэн олгож, эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.4.6. Олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор зорилтот бүлгүүдэд хүргэнэ.

2.4.7. Орон нутгийн телевизэд “Гэр бүлийн цаг” нэвтрүүлгийг бий болгож, тогтмолжуулна.

Гурав. Эдийн засаг, үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцааны талаар:

3.1. Санхүү, эдийн засаг, төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

3.1.1. Орон нутгийн татварын хувь хэмжээг оновчтой тогтоон татварын бааз суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлж, цахим тайлангийн системийг бүрэн хэрэгжүүлнэ.

3.1.2. Татвар төлөгчдөд бүсчилсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, тоон гарын үсгийг нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тайлангийн дараах ногдуулалтын хяналтын үр нөлөөг дээшлүүлж, далд эдийн засгийг илрүүлэх замаар орлогыг бодитойгоор тайлагнаж, татвар төлөлтийг нэмэгдүүлнэ.

3.1.3. Сангуудын зориулалтыг судалж, зарим сангуудыг нэгтгэн шинэчилсэн журам боловсруулан хэрэгжүүлж, сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, эргэн төлөлтийг сайжруулна.

3.1.4. Төсвийн тухай хууль, заавар, журмын хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар сургалт зохион байгуулах, төсвийн шинэ программ нэвтрүүлэх, тоног төхөөрөмж шинэчлэх замаар “шилэн данс”-ны тогтолцоог нэвтрүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.

3.1.5. Төсвийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын нягтлан бодогч, нярав, төрийн сангийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, сэлгэн ажиллуулах, нягтлан бодох бүртгэл болон тайлан тэнцлийг программаар гаргах, төрийн сангийн үйлчилгээг хүргэх, шуурхай болгох, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулна.

3.1.6. Улс, орон нутаг, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд хөндлөнгийн болон дотоодын аудит хийлгэн үнэлэлт дүгнэлт өгөх замаар ажлын гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлнэ.

3.2. Үйлдвэрлэл, худалдааны талаар:

3.2.1. Сумдад ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төв байгуулах санаачилгыг дэмжиж, шинээр жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бойжуулах, зах зээлд гарахад нь туслах үйлчилгээ үзүүлнэ.

3.2.2. Жаргалант суманд ахуйн үйлчилгээний барилгыг бүрэн ашиглалтад оруулж, үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

3.2.3. Тэжээлийн ургамал бүхий сумдад тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, жижиг үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.4. Арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг дэмжиж үйлдвэр байгуулах нөхцөлөөр хангаж ажиллана.

3.2.5. Ноос, ноолуур угаах, боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг дэмжиж үйлдвэр байгуулах нөхцөлөөр хангаж ажиллана.

3.2.6. Бетон зуурмагийн узель барих хөрөнгө оруулагчыг дэмжиж, хамтарч ажиллана.

3.2.7. Жаргалант суманд сүү боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагчдыг дэмжиж хамтарч ажиллана.

3.2.8. Дөргөн, Манхан суманд ингэний ундаа савлах цех байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.9. Сумдад шахмал түлшний үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.

3.2.10. Аймгийн төвд барилгын материалын үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.11. Аймгийн төвд хаягдал төмөр, шил, цаас, хуванцар дахин боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.2.12. Олон улсын стандартад нийцсэн махны үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.13. Булган суманд 50 тонн мах нөөцлөх зоорь байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.14. Чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 Олон улсын стандартыг аймгийн Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлнэ.

3.2.15. Байгаль орчинд нөлөөгүй ЭКО тэмдэгтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг бий болгоно.

3.2.16. Чулууны үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.17. Автовокзал, техникийн үйлчилгээний төв байгуулах санаачилгыг дэмжинэ.

3.2.18. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилгын ажлыг гүйцээж ашиглалтад оруулна.

3.3. Дэд бүтцийн талаар:

3.3.1. Түгээмэл тархацтай барилгын материалын ордуудын судалгаа явуулж нөөцийг нь тогтоон, орон нутагт тохирсон барилгын материалын үйлдвэр байгуулах техникийн нөхцөл, стандартуудыг батлуулж, тэдгээрийн хэрэглээний талаар технологийн зөвлөмжүүдийг гаргаж ажиллана.

3.3.2. Ховд-Өлгий чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барьж эхлүүлнэ.

3.3.3. Үрэмч-Ховд-Улаанбаатар чиглэлд олон улсын нислэгийг сэргээх боломжийг судлан эрх бүхий байгууллагуудад санал тавина.

3.3.4. "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл"-ийн хүрээнд Манхан-Бага улаан даваа чиглэлийн 103.3 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулна.

3.3.5. Булганы Хөвч-Үенч, Үенч-Тэмээн хүзүү чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулна.

3.3.6. Мянгадын гүүр-Сар хайрхан чиглэлийн 20 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулна.

3.3.7. Сумдад хайрган болон хатуу хучилттай авто зам, явган хүний замыг орон нутгийн санаачилгаар байгуулах ажлыг дэмжиж үргэлжлүүлнэ.

3.3.8. Аймгийн төвд 5.0 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулна.

3.3.9. Дарви сумын Байшин үзүүр-Алтай хот чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлнэ.

3.3.10. Ховд хотод “Гудамж” төсөл хэрэгжүүлэх ажлыг дэмжин хамтарч ажиллана.

3.3.11. Ховд хотын үерийн хамгаалалтын даланд засвар хийж, зарим хэсгийг нь шинэчлэнэ.

3.3.12. Булган суманд 800-аас доошгүй кВ-ын трансформатор суурилуулж, Ховд хот, Дөргөн, Алтай, Үенч, Булган сумын 04-ын шугамын засвар, шинэчлэл хийнэ.

3.3.13. МоЭнКо ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулж, Хөшөөтийн уурхайн орчимд дулааны цахилгаан станц байгуулах судалгаа хийлгэж эхлүүлнэ.

3.3.14. Ховд голын УЦС-ын ашиглалтын өмнөх захиргааг байгуулж, төслийн ТЭЗҮ, судалгааны ажлыг эхлүүлнэ.

3.3.15. Буянт голын дагуу Бугат үзүүрээс Шүүтийн тохой хүртэл ЦДАШ татаж, трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.3.16. Эрчим хүчний үнийг өдөр шөнийн ялгаатай тарифт шилжүүлэх талаар санал уламжлана.

3.3.17. Ховд хотын орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн халаалтыг +18 хэмээс доошгүй болгож, иргэд, хүүхэд, багачууд тав тухтай сурч, ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.18. Албан байгууллагуудыг үе шаттайгаар дулааны тоолууртай болгож, дулаан хангамжийн байгууллага, хэрэглэгчдийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.

3.3.19. Хоёр суманд төвлөрсөн халаалтын систем суурилуулах ажлыг Эрчим хүчний яамтай хамтран шийдвэрлэнэ.

3.3.20. Цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэлд хэмнэлттэй хэрэглэх зорилгоор айл өрх, албан газар, үйлдвэр, үйлчилгээний газруудыг усны тоолууртай болгож, цэвэр, усны үнийг бууруулах судалгаа хийж шийдвэрлэнэ. Ундны усыг цэвэршүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.3.21. Цэцэг сумын Хөшөөт тосгоны суурингийн төлөвлөгөөг боловсруулж, Хөшөөт тосгоны цогцолборыг барих ажлыг эхлүүлнэ.

3.3.22. Төв талбайн тохижилт, шинэчлэлийн ажлын дуусгаж ашиглалтад оруулна.

3.3.23. Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, Талын хашааны цэвэр бохир усны шугам сүлжээ байгуулах ажлыг дуусгана.

3.3.24. Хүн амын төвлөрөл ихтэй, төв замын ойролцоо үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх боломжтой зарим багуудын төвийг ЦДАШ-д холбоно.

3.4. Барилга, хот байгуулалт, газрын харилцааны талаар:

3.4.1. Ховд хотын ерөнхий төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, Монгол улсын жишиг “Ховд хот” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.4.2. Хувийн орон сууцны хороолол байгуулах газрыг нэгдсэн журмаар гаргаж, инженерийн байгууламжийг байгуулан иргэд өөрсдөө хувийн орон сууц барих нөхцөл бүрдүүлнэ.

3.4.3. Ховд хотод 1000 айлын орон сууцны инженерийн байгууламжийг үе шаттай байгуулж, орон сууц барих ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлнэ.

3.4.4. Газрын тухай хуулийг хэрэгжүүлж, өмчлүүлэх, эзэмшүүлэх газрыг аймаг, сумын хэмжээнд нарийвчлан тогтоож, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан мөрдөнө.

3.4.5. Зэрэг сумын “Сумын төвийн шинэчлэл” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгана.

3.4.6. Ховд хотын орон сууцны хотхоныг үйлчилгээний төв, сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэгтэй байгуулж, орчны тохижилтыг төр, хувийн хэвшлийн оролцоотой байгуулна.

Дөрөв. ХАА, байгаль орчны бодлогын хүрээнд:

4.1. Хөдөө аж ахуйн талаар:

4.1.1. Ноолуурын чиглэлийн Бумбатын улаан ямааны аж ахуй биологийн ашигтай шинж чанар, нэгжээс авах ашиг шим, эдийн засгийн үр ашгийг үргэлжлүүлэн судалж омгоор баталгаажуулна.

4.1.2. Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулж, Жаргалант, Буянт суманд мах, сүүний чиглэлийн фермерийн аж ахуй байгуулах санаачилгыг дэмжинэ.

4.1.3. Бэлчээрийн мэдээллийн санг сум, аймгийн түвшинд шинээр бүрдүүлж, мониторинг үнэлгээ хийнэ.

4.1.4. Мал сүргийн дархлаажуулах ажлыг мониторинг хийх замаар ажлын үр дүнг тооцох, малын эмч нарын хариуцлагыг өндөржүүлнэ.

4.1.5. Сумдын услалтын системийн ашиглалтыг сайжруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.6. Өвөл, зуны хүлэмж байгуулах санаачилгыг дэмжиж, шинэ ургацын ногоогоор иргэдийг хангах ажлыг зохион байгуулна.

4.1.7. Сумдад өвс тэжээлийн фонд байгуулах санаачилгыг дэмжиж, болзошгүй эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлнэ.

4.1.8. Хөдөө аж ахуйн түүхий эдийн цэвэрлэх байгууламж барина.

4.1.9. Сумдын "Малжуулах сан"-гийн хөрөнгөөр Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчдыг малжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.10. "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.1.11. Малыг гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга үйлчилгээний төсвийг нэмэгдүүлнэ.

4.1.12. Ховд суманд мах, сүүний чиглэлийн фермерийн аж ахуй байгуулах санаачилгыг дэмжинэ.

4.1.13. Артезийн худгийн усыг үр ашигтай ашиглах санаачилгыг дэмжинэ.

4.1.14. 20-иос доошгүй инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

4.1.15. Чацарганы тос, жүүс боловсруулах үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

4.1.16. Жимс жимсгэнэ, чацарганы тариалалтыг нэмэгдүүлнэ.

4.1.17. Малыг тэжээл, үр тарианы усалгаатай тариалалтыг дэмжинэ.

4.2. Байгаль орчны талаар:

4.2.1. Үйлдвэрлэл, зам, барилга, геологи, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр бэлтгэж буй төслүүдийг байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд хамруулж нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

4.2.2. Агаарын бохирдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлж, 2015 онд багтааж төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, банк, үүрэн холбоо, зочид буудал, зоогийн газар, ресторан, худалдааны төвүүд, ШТС, эмнэлэг, эрүүл мэндийн

байгууллагууд, төрөөс татаас дэмжлэг авч байгаа хувийн хэвшлийн бүх байгууллагын жижиг халаалтын зуухыг бүрэн зогсооно.

4.2.3. Байгууллага, аж ахуйн нэгж бүр эзэмшил газрын 10 –аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгоно.

4.2.4. Хулс, зэгсийг малын ялгадас, өтөг бууцтай хольж, био бордоо, малын тэжээл, шахмал түлшний зориулалтаар ашиглах зөвлөмжийг боловсруулж, менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх санаачилгыг дэмжинэ. Эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санаачилга гаргана.

4.2.5. Буянт голын ус ашиглалтын менежментийг боловсруулж, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ажиллах, эдүгээ мөрдөж буй хууль, дүрэм, журмыг зөрчсөн зөрчлүүдийг арилгана.

4.2.6. Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховордсон ургамал, амьтан элбэгтэй газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулж, шийдвэр гаргагчдад хүргүүлнэ.

4.2.7. Ирвэсэнд бариулсан малын даатгал, нөхөн олговрын тогтолцоог малчид, даатгалын байгууллага, төр, төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.8. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудитын эрх зүйн орчны шинэчлэлийн талаар сургалт сурталчилгааг зохион байгуулж, иргэдийн экологийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.2.9. Цөлжилт, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажлыг төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.10. Аймгийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал олборлолтыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийлгэнэ.

4.2.11. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2.12. Говийн унаган ургамал заг, шавгийг түлшинд хэрэглэхийг хориглож, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг дэмжинэ.

4.2.13. Хус, балгана модыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.2.14. Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховордсон ургамал, амьтны тархац нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтанд шинээр авах замаар аймгийн нийт газар нутгийн 35-аас доошгүй хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулна.

4.2.15. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2.16. Зарим сумын цаг уурын өртөөний конторын барилгыг засварлаж, автомат станц болон шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана.

4.2.17. Сумдыг хог устгах, зайлуулах техник хэрэгсэлтэй болгож, хог хаягдлыг цэвэрлэх аян зохион байгуулж, хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулж, хогийн менежментийг хэрэгжүүлнэ.

4.2.18. Ховд хотод ашиглаж байгаа уурын зуух, утаа тортог ихээр гаргадаг эх үүсвэрүүдээс агаар бохирдуулсны төлбөр авч эхэлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР